

## МӨНГӨНИЙ ТОЙМ

2017 оны 11 дүгээр сар

- Мөнгөний нийлүүлэлт 2017 оны 11 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 26.4%-иар, өмнөх сараас 2.1%-иар өсч 14.8 их наяд төгрөг болов.
- Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийг өмнөх сартай харьцуулбал хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгөнөөс бусад үзүүлэлт бууралттай байна.
- Нөөц мөнгө өмнөх сараас төдийлөн өөрчлөгдөөгүй буюу 3.4 их наяд төгрөг байна.
- Нийт хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл тайлант сард 111.7 тэрбум төгрөгөөр өсч, 13.5 их наяд төгрөг байна. Нийт зээлийн 50.0 хувь нь хувийн хэвшилд, 49.4 хувь нь иргэдэд олгосон зээл байна.
- Хадгаламжийн байгууллагуудын нийт зээлийн 6.6 хувь нь хугацаа хэтэрсэн, 8.6 хувь нь чанаргүй зээл байна. Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх сараас 0.6 нэгж хувиар, чанаргүй зээлийнх 0.2 нэгж хувиар тус тус буурчээ.

### МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

		2016		2017		
		12-р сар	3-р сар	6-р сар	9-р сар	11-р сар
<b>Инфляци</b>						
Улаанбаатар хотын	сарын	0.7	1.6	-0.6	0.5	-0.1
	оны эхнээс	0.5	3.2	4.8	6.6	6.9
	жилийн	<b>0.5</b>	<b>3.0</b>	<b>3.5</b>	<b>6.6</b>	<b>7.6</b>
Суурь	сарын	0.3	0.7	0.1	0.8	0.3
	оны эхнээс	0.5	0.9	2.7	5.0	6.6
	жилийн	<b>0.5</b>	<b>2.8</b>	<b>4.7</b>	<b>5.9</b>	<b>6.9</b>
Улсын	сарын	0.6	1.2	-0.6	0.2	0.1
	оны эхнээс	1.1	3.0	4.1	5.3	5.8
	жилийн	<b>1.1</b>	<b>3.1</b>	<b>3.3</b>	<b>5.8</b>	<b>6.5</b>
<b>Мөнгө, санхүүгийн сектор</b>						
<b>Нөөц мөнгө, тэрбум ₮</b>		3,064.4	2,749.9	3,179.5	3,269.8	3,354.9
сарын өөрчлөлт, хувиар		-5.7	2.8	6.5	-0.9	8.2
жилийн өөрчлөлт, хувиар		24.6	17.0	-9.8	5.6	3.2
<b>M2 мөнгө, тэрбум ₮</b>		12,158.6	12,260.2	13,484.1	14,749.7	14,821.8
сарын өөрчлөлт, хувиар		3.7	-0.6	3.8	1.5	2.1
жилийн өөрчлөлт, хувиар		21.0	21.2	20.5	27.6	26.4
<b>Бусад хадгаламж, тэрбум ₮</b>		10,010.8	10,134.4	10,763.5	11,949.3	12,182.3
сарын өөрчлөлт, хувиар		2.2	-0.2	2.5	1.5	2.4
жилийн өөрчлөлт, хувиар		19.7	18.8	16.9	25.3	24.4
<b>Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум ₮</b>		823.6	788.3	915.0	878.9	824.7
сарын өөрчлөлт, хувиар		7.1	-16.6	4.5	-2.3	-0.9
жилийн өөрчлөлт, хувиар		16.6	19.7	9.0	10.4	7.3
<b>Хад.байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮</b>		12,422.7	12,678.5	12,903.1	13,421.4	13,498.3
сарын өөрчлөлт, хувиар		-2.3	0.8	1.5	1.2	0.8
жилийн өөрчлөлт, хувиар		6.1	7.1	7.3	7.4	6.1
<b>Хад.байгууллагуудын чанаргүй зээлийн үлдэгдэл, тэрбум ₮</b>		1,051.7	1,035.5	1,132.3	1,169.5	1,156.0
сарын өөрчлөлт, хувиар		-9.9	-3.2	-2.2	-0.1	-1.5
жилийн өөрчлөлт, хувиар		20.9	7.0	9.3	4.5	-0.9
<b>Мөнгөний үржүүлэгч</b>		4.0	4.5	4.2	4.5	4.4
<b>Банк хоорондын зах</b>						
<b>Илүүдэл нөөц, сая төгрөгөөр</b>		-24.0	-58.7	-73.5	-56.1	-38.3
сарын өөрчлөлт, хувиар		50.3	-60.9	-127.5	-26.4	24.8
<b>Илүүдэл нөөц - Байнгын санхүүжилт</b>		-5,955.0	-24,819.1	-28,842.1	-45,500.1	-27,618.9
сарын өөрчлөлт, хувиар		81.4	-526.2	-963.0	-2,365.2	35.6
<b>Илүүдэл нөөц - ТБ-ны буцаа санхүүжилт + ОН + ТБҮЦ</b>		530,470.2	895,349.6	1,604,933.3	1,931,172.7	2,186,224.6
сарын өөрчлөлт, хувиар		-40.0	75.5	24.5	19.0	20.6
<b>Хүү (хувиар)</b>						
<b>Хадгаламжийн ЖДХ</b>		13.1	13.0	12.1	13.0	13.0
Хадгаламжийн бодит хүү*		12.6	10.0	8.6	6.3	5.4
<b>Зээлийн ЖДХ**</b>		19.7	20.2	20.3	19.9	19.6
Зээлийн бодит хүү*		19.2	17.2	16.8	13.2	12.0
Ипотекийн зээлийн хүү		10.3	10.3	10.2	10.1	10.3
ТБҮЦ-ны ЖДХ		14.5	14.0	12.9	12.0	12.0
Бодлогын хүү		14.0	14.0	12.0	12.0	12.0
БХЗ-ын ЖДХ		15.5	15.0	13.1	12.1	12.0

\* Улаанбаатар хотын хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон

\*\* Тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

### Мөнгөний нийлүүлэлт

Нийт M2 мөнгөний нийлүүлэлтийн 53.3%-ийг төгрөгийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 17.0%-ийг валютын хадгаламж, 14.0%-ийг төгрөгийн харилцах, 11.8%-ийг валютын харилцах, үлдсэн хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.


M2 мөнгөний жилийн өсөлтийн түвшин 26.4%-д хүрч өмнөх сарынхаас 1.4 нэгж хувиар өссөн байна. Жилийн өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлж төгрөгийн хадгаламжийн өсөлтөнд эзлэх хувь нь өмнөх сарынхаас 2.7 нэгж хувиар өссөн бол төгрөгийн харилцахынх 1.0 нэгж хувиар өсчээ. Харин валютын харилцахын мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд үзүүлэх хувь өмнөх сараас 2.2 нэгж хувиар, валютын хадгаламжийнх 0.6 нэгж хувиар буурав. Энэ нь төгрөгийн ханшийн алгуур чангаралт, цаашид ч чангарах хүлээлт бий болсноор тайларлагдана.

Өмнөх сараас M2 мөнгөний нийлүүлэлт 2.1% (301.2 тэрбум төгрөгөөр)-иар өсч 14.8 их наяд төгрөгт хүрсэн байна. Үүнээс M1 мөнгө 0.5% (13.0 тэрбум)-иар, бусад хадгаламж 2.4% (288.2 тэрбум)-иар тус тус өссөн байна. Бусад хадгаламжийн бүрэлдэхүүн хэсгүүдээс төгрөгийн хадгаламж 221.6 тэрбум төгрөгөөр, валютын хадгаламж 35.2 тэрбум төгрөгөөр, валютын харилцах 31.4 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тайлант сард үргэлжлэн чангарсантай холбоотойгоор төгрөгийн хадгаламж илүү өссөн байна. M1 мөнгөний бүрэлдэхүүн хэсгээс төгрөгийн харилцах 20.0 тэрбум төгрөгөөр өсч, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 7.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.


Нийт хадгаламжийн 82.8%-ийг иргэдийн хадгаламж бүрдүүлж байна. Харин гадаад валютын хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь 24.2%-д байгаа нь өмнөх сарын түвшингээс бага зэрэг буурсан байна. Хэдийгээр эзлэх хувь бага зэрэг буурч байгаа ч банкны салбарын пассивын долларжилт харьцангуй өндөр хэвээр байна.

Тайлант сард иргэдийн гадаад валютын хадгаламж өмнөх сараас 1.9%-иар өссөн бол байгууллагын валютын хадгаламж 0.3%-иар буурч, нийт дүнгээр 1.4%-иар өссөн байна.

Зураг 1. Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн (эх үүсвэрээр)



Зураг 2. M2 мөнгөний жилийн өсөлт



Зураг 3. Мөнгөний нийлүүлэлтийн сарын өөрчлөлт, тэрбум ₮



Зураг 4. Хадгаламжийн үлдэгдэл (иргэд, байгууллага)




### Гадаад, дотоод актив

M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив өмнөх сараас 1147.5 тэрбум төгрөгөөр өсч, дотоод цэвэр актив 846.3 тэрбум төгрөгөөр буурсан байна. Гадаад цэвэр активын өөрчлөлтөөс Төв банкны гадаад цэвэр актив 1399.0 тэрбум төгрөгөөр өсч, хадгаламжийн байгууллагуудынх 251.0 тэрбум төгрөгөөр буурсан байна. Харин дотоод цэвэр активын өөрчлөлтөд Төв банкны дотоод цэвэр актив 1144.7 тэрбум төгрөгөөр буурч, хадгаламжийн байгууллагуудынх 298.4 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.


Нийт хадгаламжийн байгууллагуудын дотоод активаас Засгийн газраас авах цэвэр авлага 1005.3 тэрбум төгрөгөөр буурч, иргэдээс авах авлага 102.9 тэрбум төгрөгөөр, бусад санхүүгийн байгууллагынх 220.0 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Тайлант сард нөөц мөнгө 3.4 их наяд төгрөг байгаа нь өмнөх сараас 254.3 тэрбум төгрөг буюу 8.2 хувиар өссөн байна. Нөөц мөнгөний 75.5 хувийг банкуудын Төв банк дахь харилцах, 16.7 хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, 7.8 хувийг банкуудын касс дахь мөнгө бүрдүүлж байна.

Зураг 5. Төв банк, хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод цэвэр актив



Зураг 6. Нөөц мөнгө




### Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл

Хадгаламжийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх сараас 111.7 тэрбум төгрөгөөр өсч 13.5 их наяд төгрөг байна. Нийт зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 6.1 хувь, иргэдэд олгосон зээлийн үлдэгдлийнх 18.2 хувь байгаа бол хувийн хэвшлийнх 3.0 хувиар буурсан байна. Үүнээс харахад банкууд эрсдэл харьцангуй багатай байгаа цалин, тэтгэвэр зэрэг хэрэглээний зээлийг олгож, харин чанаргүй зээлийн хувь өндөртэй байгаа бизнесийн зориулалттай зээл олголтыг хумьсан хэвээр байна.


Нийт зээлийн үлдэгдлийн 50.0 хувийг хувийн хэвшилд, 49.4 хувийг иргэдэд, 0.6 хувийг бусад салбарт олгосон зээл бүрдүүлж байна.

Зураг 7. Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх сарынхаас 0.6 нэгж хувиар буурч 6.6 хувьд хүрсэн бол чанаргүй зээлийн эзлэх хувь өмнөх сарынхаас 0.2 нэгж хувиар буурч 8.6 хувь байна. Хугацаа хэтэрсэн зээлийн 83.3 хувийг, чанаргүй зээлийн 79.8 хувийг хувийн хэвшилд олгосон зээл эзэлж байна. Ийнхүү хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь буурахад эдгээр зээл биет хэмжээгээр буурсан нь голлон нөлөөлжээ.


Зураг 8. Хадгаламжийн байгууллагуудын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл



**Мөнгөний зах**

Тухайн сард банк хоорондын мөнгөний захаар дамжуулан банкууд 548.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Үүний 52.7 хувийг овернайт зээл, 23.2 хувийг Төв банкны үнэт цаасны шууд арилжаа, 18.9 хувийг ТБҮЦ-ны репо арилжаа, 4.9 хувийг банк хоорондын хадгаламж тус тус бүрдүүлжээ.

Зураг 9. Банк хоорондын захын арилжааны дүн, хүү




Банкууд заавал байлгах нөөцийн шаардлагыг хангах, тооцоо, гүйлгээний зорилгоор 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 7-ны өдрийн хооронд 1365.7 тэрбум, 2017 оны 11 дүгээр сарын 8-ны өдрөөс 21-ний өдрийн хооронд 1370.1 тэрбум төгрөгийг Монголбанк дахь төгрөгийн харилцахад, дээрх хугацаанд харгалзан 614.7 тэрбум болон 608.3 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний валютыг валютын харилцах дансанд тус тус байршуулжээ.


**Хүү**

Тайлант сард төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сарынхаас 0.3 нэгж хувиар буурч 19.6%, үлдэгдэлд жигнэсэн хүү 0.1 нэгж хувиар буурч 18.1%-д тус тус хүрчээ. Зээлийн үлдэгдлийг хугацаагаар нь ангилан харвал 4 сараас 36 сар хүртэлх хугацаатай зээлийн хүүнүүд 20% орчимд, 3 сар хүртэлх хугацаатай зээлийн хүүнүүд 17% орчимд, 37-60 сар хүртэлх хугацаатай зээлийн хүүнүүд 18 хувь байна. Харин 60 сараас дээш хугацаатай зээлийн хувьд 14% байна. Шинээр олгосон зээлийн хувьд 7-60 сар хүртэлх хугацаатай зээлийг 20-21% орчимд олгосон байхад 60

Зураг 10. Зээлийн жигнэсэн дундаж хүү (төгрөг)




Зураг 11. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (төгрөг)




сараас дээш хугацаатайг 17%, 3 сар хүртэлхийг 18% орчим хувиар тус тус олгосон байна. Сектороор ангилан харвал хувийн байгууллагад олгосон зээлийн хүү 18.5%, иргэдэд олгосон зээлийн хүү 20.3% байна. Валютын зээлийн хувьд тухайн сард шинээр олгосон зээлийн хүү өмнөх сарынхаас 2.0 нэгж хувиар өсч 11.8%, харин зээлийн үлдэгдлээр жигнэсэн хүү өмнөх сарын түвшинд буюу 11.3% байна. Шинээр олгосон зээлийн хүү ийнхүү өмнөх сараас өссөн нь өмнөх сард бага хүүтэй гадаад эх үүсвэрийн зээл хувийн хэвшилд олгогдсоноор өмнөх сарын хүү буурсантай холбоотой байна.

Төгрөгийн хадгаламжийн үлдэгдлээр жигнэсэн хүү өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурч 13.0%, тухайн сард татсан хадгаламжийн жигнэсэн хүү 0.7 нэгж хувиар буурч 12.3%-д тус тус хүрчээ. Гадаад валютын хадгаламжийн хувьд үлдэгдлээр жигнэсэн хүү өмнөх сараас 0.4 нэгж хувиар өсч 5.6%, шинээр татсан хадгаламжийн хүү 0.1 нэгж хувиар өсч 5.4% болжээ.



Зураг 12. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (валют)



Зураг 13. Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш


### Валютын ханш

2017 оны 11 дүгээр сарын байдлаар Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш өмнөх сарынхаас 0.4 хувиар чангарч 2448.9 төгрөг байв. Тухайн сарын хамгийн өндөр ханш 2456.2 төгрөг байсан бол хамгийн бага нь сарын эцэст 2443.6 төгрөг байв. Сарын эцсийн ханш өмнөх сарынхаас 0.5 хувиар чангарсан байна.



Зураг 14. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш

БНХАУ-ын юаньтай харьцах дундаж ханш өмнөх сарынхаас 0.3 хувиар чангарч 369.8 төгрөг байв. Тухайн сарын хамгийн өндөр ханш нь 372.0 төгрөг байсан бол хамгийн бага нь 368.3 төгрөг байв. Харин сарын эцсийн ханш 369.8 төгрөг буюу өмнөх сарынхаас 0.2 хувиар чангарсан байна.




## Инфляци

2017 оны 11 дүгээр сард инфляци УБ хотын хэмжээнд өмнөх сараас 0.1 хувиар буурсан байна. Үүнээс хүнсний барааны үнэ 1.0 хувиар буурч, хүнснээс бусад барааны үнэ 0.24 хувиар өссөн байна. Тодруулбал, сарын өсөлтийн 0.18 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнэ, -0.25 нэгж хувийг хүнсний барааны үнэ бүрдүүлжээ. Хүнснээс бусад барааны өсөлтөд түлшний эм тариа, гар ахуйн тавлига, гоо сайхны хэрэгцээнд зориулсан эд зүйлсийн үнийн өсөлт гол нөлөө үзүүлсэн байна. Харин хүнсний бүлгийн үнэ буурахад хонь, ямааны мах болон луувангийн үнийн бууралт гол нөлөө үзүүлэв.

Жилийн инфляци УБ хотын хэмжээнд тайлант сард 7.6 хувь байгаагийн 5.1 нэгж хувийг хүнснээс бусад бараа, үйлчилгээ, 2.5 нэгж хувийг хүнсний бараа, бүтээгдэхүүн бүрдүүлсэн байна.

Хүнсний бүлгийн үнэ жилийн 10.7 хувийн өсөлттэй байгаагаас хүнсний ногооны үнэ 17.7 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 13.1 хувиар, мах, махан бүтээгдэхүүний үнэ 11.1 хувиар өсчээ. Харин хүнснээс бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ жилийн 6.7 хувийн өсөлттэй байгаагаас тээвэр 9.8 хувиар, орон сууц, ус, цахилгааны үнэ 10.0 хувиар, боловсролын бүлгийн үнэ 7.5 хувиар өсчээ.

Зураг 14. Улаанбаатар хотын сарын инфляци



Зураг 15. Улаанбаатар хотын жилийн инфляци

